



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 326

Улаанбаатар хот

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
төрийн өмчит хувьцаат компанийн
2018 оны их засвар, техник зохион
байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 665 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн 12-т “Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалт 6,775.6 сая төгрөг” гэснийг “Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалт 10,359.5 сая төгрөг” гэж өөрчилсүгэй.

2. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2017 оны 091/40 дүгээр заавал биелүүлэх албан шаардлагын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны төлөвлөгөө батлах тухай” 665 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хавсралтад заасан төсөл, арга хэмжээг нэмсүгэй.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн
326 дугаар тогтоолын хавсралт



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН 2018 ОНЫ ИХ ЗАСВАР, ТЕХНИК ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА
ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД НЭМЭГДЭХ
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (мянган төгрөг)	Нийт үнэ (мянган төгрөг)
Их засварын ажил					
22	Хэрлэн-Булган 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам шинэчлэх	ком	1	2 896 744,8	2 896 744,8
23	Ажиллагсдын соёл, спортын төвийн их засвар	ком	1	687 140,6	687 140,6
	НИЙТ ДҮН				3 583 885,4